



ГАЗРЫН ХАРИЛЦАА,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/138

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.12, 23.2.14, 23.2.17 дахь хэсэг, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх ажлын заавар"-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан зааврыг хэрэгжүүлэн ажиллахтай холбогдуулан байгууллага, албан тушаалтанд дараах чиг үүргийг үүрэг болгосугай. Үүнд:

2.1 Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын болон нэгжийн дарга, мэргэжилтнүүд, сумын Газрын даамал нарт сургалт, үйлдвэрлэлийн дадлагыг аймаг тус бүрт зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдлийг нэг бүрчлэн тоон архивтай тулган баталгаажуулж Лэнд менежер програм хангамжинд оруулахыг Кадастрын хэлтэс /Б.Галмандах/-т,

2.2 Сумын газрын даамал, гэрээт ажлын гүйцэтгэгчийн хоорондын уялдаа холбоог хангах, ажлын гүйцэтгэлийн явцад тулгамдаж буй асуудлын шийдвэрлэх арга замыг тодорхойлж, орон нутгийн удирдлагатай зөвшилцөж шийдвэрлүүлж, дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга нарт,

2.3 Тухайн суманд газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх үүссэн бүх нэгж талбарыг газрын улсын бүртгэлд хамруулж, тэдгээрийн тоон болон цаасан хувийн хэргийг буй болгох ажлыг гүйцэтгэгчтэй хамтран хийхийг сумын Газрын даамал нарт,

2.4 "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх ажил"-ыг батлагдсан заавар, гэрээт ажлын "Ажлын даалгавар"-ын дагуу хугацаанд нь хийж, гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг гэрээт ажлын гүйцэтгэгч /Геомастер ХХК/-д,

3. "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажилд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж дэмжлэг үзүүлж, идэвхи санаачлагатай оролцохыг сумын Засаг дарга зөвлөмж болгосугай.

4. Батлагдсан зааврыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын Газрын даамал, гүйцэтгэгч компаниудад хүргүүлж үйл ажиллагаанд мөрдүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын удирдлагын алба /Р.Ганхуяг/-нд, дээрх ажлуудыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Захиргаа, санхүүгийн алба /Г.Цэцгээ/-нд даалгасугай.

ДАРГА



А.ХҮРЭЛШАГАЙ